



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ
САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ӨВА-2021/96/-ШТА-ГА

Арвайхээр хот
2021 он

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор **О.Батжаргал**
Утас: 70323253, цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn
Аудитын менежер Д.Гансүх,
Утас: 70323833, цахим хаяг: Gansukhd@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Хорлоосүрэн,
Утас: 70323108, цахим хаяг: Khorloosuren@audit.gov.mn
Аудитор: Э.Энхбаяр,
Утас: 70323108, цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn
Ө.Ринчинмядаг,
Утас: 70323108, цахим хаяг: RinchinmyadagaU@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	2
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	2
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	2
БҮЛЭГ 1. МАЛ ЭМНЭЛГИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨРӨНГИЙГ ҮНДЭСЛЭЛГҮЙ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.	5
1.1. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эм бэлдмэлийн захиалгын төлөвлөлт үндэслэл муутай байна.	5
1.2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд орон нутгийн төсвөөс олгож буй хөрөнгийг мал эмнэлгийн нэгжүүдэд харилцан адилгүй хувиар олгосон байна.	7
1.3. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээний жишиг үнэлгээг тогтоосон тооцоолол байхгүй байна.	7
БҮЛЭГ-2. МАЛ ЭМНЭЛГИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ БҮРЭН ХИЙГДЭЭГҮЙ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.	8
2.1. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хугацаандаа нийлүүлэгдээгүй, зарим мал эмнэлгийн нэгжүүд хангалтгүй ажиллаж байна.	8
2.2. Мал эмнэлгийн ажил үйлчилгээний зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.	12
2.3. Хувийн мал эмнэлгүүдийн ажиллах орчин нөхцөл тааруу, үйлчилгээний чанар хүртээмж хангалтгүй байна.	13
2.4. Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийн үйл ажиллагаа хуулийн дагуу явагдсан боловч өөрийн орлогоо төсөвт тусгаагүй байна.	15
БҮЛЭГ-3. МАЛ ЭРҮҮЛЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТЫН ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА.	16
3.1. Аймгийн Мал эмнэлгийн газраас сумын мал эмнэлгийн тасгуудад жил бүр хяналт, шалгалт хийгдсэн боловч хяналт, шалгалтын дагуу сумдад өгөгдсөн зөвлөмжийн биелэлт байхгүй байна.	16
3.2. Сумын мал эмнэлгийн улсын байцаагч нарын хувийн мал эмнэлгийн нэгжид тавих хяналт хангалтгүй байна.	17
3.3. Журмын дагуу мэдээллийг бүрэн хөтөлсөн боловч мэдээ, тайлангийн тоон үзүүлэлт зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.	18
3.4. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээний явц чанарт аймгийн МХГ-аас хяналт тавьж ажилласан байна.	20



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуй нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт.
ГА	Гүйцэтгэлийн аудит
ЗД	Засаг дарга
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
МЭГ	Мал эмнэлгийн газар
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
МЭНС	Мал эмнэлгийн нэгдсэн систем
МЭТ	Мал эмнэлгийн тасаг
МЭҮН	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ӨВА	Өвөрхангай аймаг
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАГ	Төрийн аудитын газар
УМЭАЦТЛ	Улсын Мал Эмнэлэг Ариун цэврийн төв лаборатори
ШТА	Шууд төлөвлөгөөт аудит

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График-1	2019, 2020 оны аймгийн хэмжээнд нийт малын урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан тоон үзүүлэлт
График-2	2019, 2020 оны урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малын тоон өөрчлөлт

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт-1	Урьдчилан сэргийлэх тарилгын тарифын зөрүү
Хүснэгт-2	Зориулалт бусаар зарцуулсан зардлын жагсаалт
Хүснэгт-3	Шимэгчлэх өвчнөөс сэргийлэх арга хэмжээний 2020 оны жилийн эцсийн мэдээний тулгалт
Хүснэгт-4	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн 2020 оны жилийн эцсийн мэдээний тулгалт
Хүснэгт-5	Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас өгсөн үнэлгээ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг-1	Мал угаалгын ванны зураг /Доторх бохир зайлуулаагүй, дотор нь мал үхсэн/
Зураг-2	Гучин-Ус сумын Өөш шахлага эмнэлэг /халаалтгүй/
Зураг-3	Зүүнбаян-Улаан сумын Сонжин дөрөлж эмнэлэг /ажиллах орчин муу/
Зураг-4	Баруунбаян-Улаан сумын Баян бударгана эмнэлэг /гэрийнхээ 1 давхарт, хойш харсан хаалгатай/



АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аймгийн ИТХ-ын захиалгыг үндэслэн “Аудитын төлөвлөгөө батлах тухай” МҮЕА-ын 2021 оны А/28 дугаар тушаал, Өвөрхангай аймаг дахь ТАГ-ын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 10 дүгээр зүйлийн 10.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд ӨВА-2021/96-ШТА-ГА кодтой Аймгийн Мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах хөтөлбөрийн хэрэгжилтэд аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт

Аймгийн Мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах хөтөлбөрийн хэрэгжилт хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг аймгийн ИТХ-д болон МЭГ, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэсэн.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийсэн.Үүнд:

1. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хөрөнгийг үндэслэлтэй төлөвлөж байгаа эсэх;
2. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хөрөнгийг үр дүнтэй зарцуулж байгаа эсэх;
3. Мал эрүүлжүүлэх хөтөлбөрүүдийн үйл ажиллагаанд тавих хяналт үр дүнгээ өгсөн эсэх.

Аудитын хамрах хүрээ

Аудитыг аймгийн Мал эмнэлгийн газар болон Арвайхээр, Гучин-Ус, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Хайрхандулаан, Зүүнбаян-Улаан сумдын мал эмнэлгийн тасаг болон хувийн мал эмнэлгийн ажлын баримт, материалд тулгуурлан 2019-2020 оны МЭГ-ын хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд улс, орон нутгийн төсвөөс хуваарилж олгосон санхүүжилт, бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгийг хэрхэн зарцуулсан талаар тэдний гүйцэтгэсэн ажлын тайлан, мэдээ, холбогдох бусад материалд тулгуурлан гүйцэтгэв.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100, 400, 4100, Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит.Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит”, стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “ТАБ-аас аудит хийх журам”-ыг баримтлан шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, санал асуулга авах, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашигласан.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд

Дараах хууль эрхийн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана.

Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль



**Аудит хийх
бүрэлдэхүүн**

- Хөдөлмөрийн тухай хууль
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль
- Малын генетик нөөцийн тухай хууль
- Малын генетик нөөцийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, тайлагнах журам
- Монгол мал үндэсний хөтөлбөр
- Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөр
- “Мал, амьтны гоц халдварт өвчний жагсаалт батлах тухай” засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоол
- “Мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, тайлагнах журам” Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны тушаал
- Аймгийн ИТХ, ЗД-аас гаргасан тогтоол, шийдвэрүүд.

Аудитыг аймаг дахь ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал удирдан, аудитын менежер Д.Гансүх чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор П.Хорлоосүрэн, аудитор Ө.Ринчинмядаг, Э.Энхбаяр нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Ерөнхий мэдээлэл:

Аймгийн мал эмнэлгийн газар нь 2019 оны 1 дүгээр сарын 01-нээс Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

Өвөрхангай аймгийн Мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах талаар “Аймгийн мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах хөтөлбөр”, “Монгол мал үндэсний хөтөлбөр”, “Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрүүд” хэрэгжиж байна.


Өвөрхангай аймгийн мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах талаар 2019 онд хувийн мал эмнэлгүүдэд –Халдварт боом, галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд 35314.3 мянган төгрөг, шүлхий болон халдварт бруцеллёз өвчний санхүүжилтэд 637769.5 мянган төгрөг, бусад шинжилгээний зардалд 454575.6 мянган төгрөг, тарилгын үйлчилгээний хөлсөнд 187054.4 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

2020 онд Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах зардалд аймгийн засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/14 дүгээр захирамжаар зарцуулагдах вакцины үнэнд 214597.3 мянган төгрөг, Мал эмнэлгийн үйлчилгээний хөлсөнд 439480.0 мянган төгрөг нийт 654077.0 мянган төгрөгийг суулган Биокомбинат болон МЭҮ-ийн нэгжүүдэд төсвийг хуваарилсан байна.

Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд 333642.2 мянган төгрөг, Монгол мал үндэсний хөтөлбөрийн зардалд 154164.5 мянган төгрөг зарцуулсан байна.

Аймгийн мал эмнэлгийн газар нь Мал, амьтны эрүүл мэндийн алба, Захиргаа санхүүгийн алба, Мал эмнэлгийн лаборатори гэсэн 3 албатай, 19 суманд тасгын дарга, тархвар зүйчийн орон тоотой үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Аудитаар 995.6 сая төгрөгийн үр өгөөж тооцож, 6 зөвлөмж, 68.4 сая төгрөгийн албан шаардлагыг аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлж байна.



Мал эмнэлгийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, үйлчилгээний чанар хангалтгүй, улсын байцаагч нар хяналт тавьж ажиллаагүй байна.

БҮЛЭГ 1. МАЛ ЭМНЭЛГИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨРӨНГИЙГ ҮНДЭСЛЭЛГҮЙ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

1.1. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эм бэлдмэлийн захиалгын төлөвлөлт үндэслэл муутай байна.¹

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 58.2.12-д заасныг үндэслэн ОНХС-гаас аймгийн мал, амьтны халдварт, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2019 онд 439480.0 мянган төгрөг, 2020 онд 439480.0 мянган төгрөгөөр баталсан байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2019 онд 9 нэр төрлийн, 2020 онд 8 нэр төрлийн вакцин ийлдсийг сүүлийн 5 жилийн халдварт өвчний судалгаа, халдварт өвчний зураглалыг үндэслэн 2019 онд 1778.3 мянган толгой малд хийхээр төлөвлөж 1768.5 мянган толгой малыг, 2020 онд 1216.0 мянган толгой малд хийхээр төлөвлөж 1212.8 мянган толгой малыг тус тус вакцинжуулсан байна.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдалтын хувь

	Нийт малын тоо	Вакцинд хамруулахаар төлөвлөсөн малын тоо	Вакцинд хамрагдсан малын тоо	Вакцинд хамрагдалтын хувь
2019	5,625.5	1,778.3	1,768.5	31.4
2020	4,479.1	1,216	1,212.8	27

График-1 2019, 2020 оны аймгийн хэмжээнд урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдвал зохих, хамрагдсан малын тоо

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ариутгал, халдваргүйтгэл хийхэд шаардлагатай эм бэлдмэлийн захиалгыг төлөвлөхдөө Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 8.2-д “ Энэ хуулийн 8.1-д заасан тархвар зүйн судалгааны хүрээнд сум, дүүргийн мал эмнэлгийн тасаг дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны А/187 тоот тушаалын долоо дугаар хавсралтаар батлагдсан “Тархвар зүйн судалгааны хуудасны загвар, судалгаа хийх төлөвлөгөө” зааврын дагуу тархвар зүйн мэргэжилтэн тархвар зүйн судалгаа хийж түүний үр дүнд үндэслэсэн байна.

Мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хууль журмын дагуу төлөвлөсөн эсэхийг авч үзэхэд урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах бог, бод малын тоо зөрүүтэй байхад 2019, 2020 оны төсөв адилхан батлагдсан байна.


Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан бог мал, бод малын тооны өөрчлөлт /мян.тоо/

■ Бог мал ■ Бод мал ■ Нийт мал



График-2 2019, 2020 оны урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малын тоо /бог, бод/

¹ 58.2.12.мал, амьтны халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээг үзүүлэх;



Тухайлбал: МЭҮН-үүдийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2019 онд 1778.3 мянган мал хамрагдаж 439480.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан, 2020 онд 1216.0 мянган мал хамрагдаж 439480.0 мянган төгрөгийн санхүүжилт авч малын тоо нь өмнөх оноос 562.3 мянган мал буюу 31.6 хувиар буурсан байхад төсөв нь адилхан батлагдсан байна.

Сангийн яамнаас малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг үндэслэлгүй төлөвлөж байна гэсэн шалтгаанаар санхүүжилтийг бууруулан баталсан байна.

Сангийн яамнаас батлагдсан төсөвт багтаан үйлчилгээний хөлсөө аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан тарифаас бага хуваарилж байна. Жишээ нь:

Хүснэгт-1		Урьдчилан сэргийлэх тарилгын тарифын зөрүү /мян.төг/				
№	2020 оны байдлаар	Урьдчилан сэргийлэх тарилга	Бог	1тун	2тун	Үйлчилгээний хөлс
1	Баян-Өндөр сумын Угалзхангай мал эмнэлэгт олгосон санхүүжилт	ДХХ/ДХХ-Энтербактериоз	40000	0.17	0.17	13600.0
2		Цусан халдварт	2400	0.33	0.33	1584.0
3		Дуут	2000	0.33		660.0
	Дүн					15844.0
1	ИТХТ-ийн 2014 оны 45 тоот тогтоолоор батлагдсан тариф	ДХХ/ДХХ-Энтербактериоз	40000	0.3	0.3	24000.0
2		Цусан халдварт	2400	0.4	0.4	1920.0
3		Дуут	2000	0.4		800.0
	Дүн					26720.0
	Зөрүү					-10876.0

Дээрх хүснэгтээс харахад тогтоолын дагуу тарифыг тооцож үзэхэд 26720.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор байтал төсөв хүрэлцэхгүйгээс 15844.0 мянган төгрөгөөр буюу 40.7 хувиар дутуу санхүүжилт олгосон байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардлын санхүүжилт дутуу батлагдсан нь гэсэн шалтгаанаар төсвийн саналыг бууруулан ирүүлж аймгийн ИТХ-аар баталж ирсэн байна. Энэ нь аймгийн ИТХ Сангийн яамнаас тогтоосон төсвийн хэмжээг бодит нөхцөл байдалд болон төсвийн саналд тулгуурлан өөрчлөх эрхгүйгээр шууд баталж байгаатай холбоотой байна. */Хавсралт1/*

Халдварт өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааны төсвийн саналаа сумдын тасгийн мэргэжилтнүүдийн халдварт өвчлөлийн тархвар зүйн судалгаанд үндэслэн аймгийн Мал эмнэлгийн газар хүргүүлдэг гэсэн боловч тухайн жилийн судалгаа нь Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны А/187 тоот тушаалын долоо дугаар хавсралтаар батлагдсан “Тархвар зүйн судалгааны хуудасны загвар, судалгаа хийх төлөвлөгөө” зааварт нийцээгүй байна.

Мөн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах малын тоо болон төсвийн саналыг аймгийн МЭГ-аас хуваарилахдаа сумдын төлөвлөсөн зардлыг үндэслэхгүй аймгийн төсвөөс хуваарилсан санхүүжилттэй холбоотой хуваарилсан гэсэн тайлбар өгч байна.

Төлөвлөлт үндэслэлгүйгээс мал амьтад урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамрагдаж чадахгүй байна.

Аймгийн Мал эмнэлгийн газрын мэргэжилтэн нь сумдаас ирж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний захиалга бодит биш хэт их өсгөж ирүүлдгээс бид тухайн орон нутгийн тархвар зүйн судалгаа, зураглалыг үндэслэн сумдын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажилд хамрагдах малын тоог бууруулж үйлчилгээний хөлсөө хуваарилдаг гэсэн тайлбар өгч байгаа нь төлөвлөлт үндэслэлгүй байгааг харуулж байна.

Сум болгонд мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчийн орон тоо батлагдсан боловч одоогийн байдлаар 19 сумын 8 суманд тархвар зүйчийн орон тоонд мэргэжилтэн



ажиллаагүйгээс сумын улсын байцаагч нь давхар ажиллаж байгаа нь урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлт үндэслэлгүй байх бас нэгэн шалтгаан болж байна.

1.2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд орон нутгийн төсвөөс олгож буй хөрөнгийг мал эмнэлгийн нэгжүүдэд харилцан адилгүй хувиар олгосон байна.

Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хуваарилахдаа сумын мал эмнэлгийн анхан шатны нэгжээс өвчлөл гарах эрсдэл бүхий малын тоог гарган МЭҮН-үүдэд олгох төсвийн хуваарийг халдварт өвчний тархвар зүйн судалгаа, халдварт өвчний зураглал, харьяа малын тоо, өмнөх жилүүдийн гүйцэтгэл зэргийг харгалзан тооцоолж, аймгийн Засаг даргаар батлуулан мөрджээ.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд аймгийн Засаг даргын захирамжаар орон нутгийн төсвөөс 2019 онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах вакцины үнэнд 262309.7 мянган төгрөг сумдын мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд ОНХС-ийн төсвөөс 439480.0 мянган төгрөг, 2020 шаардагдах вакцины үнэнд 214597.3 мянган төгрөг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд ОНХС-ийн төсвөөс 439480.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Сумын мал эмнэлгийн тасаг тархвар зүйн судалгааг хийхдээ дараах зүйлүүдийг үндэслэж хийх шаардлагатай. Тухайлбал: малын өвчлөлийг бүс нутгаар нь оновчтой төлөвлөн шаардлагатай мэдээ, мэдээллийг тасралтгүйгээр системтэй цуглуулж, дүн шинжилгээ хийж, шаардлагатай статистикийн мэдээллийг харьяалах нутгийн захиргааны байгууллагаас гаргуулан авах, мал эмнэлгийн үзлэг, лабораторийн шинжилгээ хийлгэх ажил зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байх шаардлага байна.

MNS 5368:2018 Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагааны стандартын 7.1.3-т “Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээ хэрэгжүүлэх үед нэг малын эмчийн хариуцах малын тоо хонин толгойд шилжүүлснээр дөчин мянга (40000)-аас ихгүй байна” гэж заасан байна. Энэ нь мал эмнэлгийн ерөнхий мэргэжлийн тусламж, үйлчилгээний нэгжид тавих нийтлэг шаардлага бөгөөд МЭҮН-үүдийн эмч нарт энэ шаардлагад нийцүүлж малын тоог хуваарилаагүй байна. */Хавсралт2/*

МЭҮН-үүдийн малын эмч нар ачааллыг энэ шаардлагад нийцсэн байгаа эсэхийг үзэхэд нэг малын эмчид оногдож байгаа малын тоо янз бүр байна.

Цаашид аймгийн МЭГ-аас халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг бодитоор үнэлж, нэг малын эмчид ногдох малын тоог стандартын дагуу мөрдөж ажиллах шаардлагатай байна.

1.3. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээний жишиг үнэлгээг тогтоосон тооцоолол байхгүй байна.

Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2015 оны 10/02 тоот тогтоолоор “Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний жишиг үнэлгээний жагсаалт батлах тухай” тогтоол, ИТХТ-ийн 2014 оны 45 дугаар тогтоолоор “Урьдчилан сэргийлэх тарилга, лабораторийн шинжилгээний тариф”-ыг тогтоож баталсан байна. Үүнд:

- ◆ Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга бод толгой тутам 400 төгрөг, бог толгой тутам 300 төгрөг,
- ◆ Лабораторийн шинжилгээний сүрьеэлүүр болон ямлуурын тарих, шалгах толгой тутам 500 төгрөг, цуснаас дээж авах нэг дээж нь 500 төгрөг байна.

Тус тогтоолоор батлагдсан үйлчилгээний тариф нь нарийн тогтоосон тооцоо, судалгаа байхгүй, юуг үндэслэсэн нь тодорхойгүй байна.



Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүжилт төлөвлөсөн хэмжээнээс буурснаас шалтгаалан батлагдсан төсөвт тааруулан бод малд 330 төгрөг, бог малд 170 төгрөгөөр тооцож олгосон байна. Хэдийгээр батлагдсан төсөвт тааруулан хуваарилалтыг хийж байгаа ч МЭҮН-үүдэд төсөв хэрхэн хуваарилсан нарийн тооцоолол байхгүй, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах мал амьтны тоог хэрхэн сонгож байгаа нь тодорхойгүй байна.

БҮЛЭГ-2. МАЛ ЭМНЭЛГИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ БҮРЭН ХИЙГДЭЭГҮЙ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

2.1. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хугацаандаа нийлүүлэгдээгүй, зарим мал эмнэлгийн нэгжүүд хангалтгүй ажиллаж байна.²

Аймгийн ИТХТ-ийн 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 70 дугаар тогтоолоор “Мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах” хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/557 дугаар захирамжаар “Аймгийн мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 4 жилээр гаргаж баталсан байна.

Тухайн хөтөлбөрийн зорилтууд:

- ◆ Мал эмнэлгийн нэгжийн материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжилтний хүрэлцээ хангамж, чадавхыг сайжруулах
- ◆ Мал, амьтны өвчний оношилгоо, шинжилгээний чадавхыг сайжруулах
- ◆ Мал эмнэлгийн дуудлага үйлчилгээний шуурхай бэлэн байдлыг хангах
- ◆ Мал, амьтны шилжилт, хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах /малчдын хариуцлагыг өндөржүүлэх/
- ◆ Нийгмийн эрүүл мэнд, эдийн засагт хохирол учруулдаг малаас хүнд халдварладаг зооноз өвчний гаралт, тархалтаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийтийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ зохион байгуулах
- ◆ Малын гоц халдварт, халдварт өвчний тандалт шинжилгээ хийж, гоц халдварт, худалдааны хорио цээрт өвчнөөр эрүүл баталгаа гаргаж, зарим вакцинжуулалтын ажлын үр дүнг тооцох
- ◆ Гэрийн тэжээвэр амьтдаас халдварладаг халдварт, паразиттай өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах гэсэн байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг 2019-2020 онд авч үзэхэд:


Мал эмнэлгийн нэгжийн материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжилтний хүрэлцээ хангамж, чадавхыг сайжруулах чиглэлээр:

ОНХС-ийн хөрөнгөөр Баян-Өндөр, Баруунбаян-Улаан, Гучин-Ус, Тарагт, Нарийнтээл сумуудад мал угаалгын ванн баригдсан, Сант сумын “Булангийн харз”, Өлзийт сумын “Баян ханхал” МЭҮН-үүд өөрийн хөрөнгөөр портер автомашин худалдан авсан байна.

Аймгийн хэмжээнд 2019 онд нийт 19 багт суурин ванн баригдахаас 11 ванн баригдаж, 1 тоноглогдсон авто машин, 1 дук машин, 20 ширхэг зөөврийн хашаа нийлүүлсэн байна.

МЭНС-д нэвтэрсэнтэй холбогдуулан мал эмнэлгийн газрын даргын албан тоотын дагуу сумдын мал эмнэлгийн нэгжүүдэд мал эмнэлгийн гэрчилгээ хэвлэх гар принтер сумдын төсвийн хөрөнгөнөөс 3550.0 мянган төгрөг зарцуулсан байна.

² 21.1. Мал эмнэлгийн тасаг тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжтэй хамтран энэ хуулийн 8.1-д заасан тархвар зүйн судалгаа хийж, мал, амьтны шимэгчтэх өвчин /цаашид “шимэгчтэх өвчин” гэх/-ийг тандах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.



Сумдын мал эмнэлгийн тасгийн мэргэжилтний орон тоо дутуу хүрэлцээ хангамж муутайгаас ажил эзэнгүйдсэн байдалтай байна. Тухайлбал: Сайдын тушаалаар батлагдсан сумдын тасгийн мэргэжилтэн 38 орон тоотой боловч 27 орон тоон дээр мэргэжилтнүүд ажиллаж 11 орон тооны мэргэжилтэн дутуу ажиллаж байна. Хайрхандулаан сум гэхэд нэг ч мэргэжилтэн байхгүй хувийн мал эмнэлгүүдийн хяналт байхгүй ажил яаж явагддаг нь тодорхойгүй тул тухайн суман дээр төрийн ажил цалгардсан байдалтай байна. Цаашид боловсон хүчний хүрэлцээ хангамж, чадавхыг сайжруулж, сумдын орон тоог бүрэн ажиллуулах шаардлагатай байна. Сумдын мал эмнэлгийн улсын байцаагчийн орон тоо бүрэн ажилласнаар сумдын хувийн мал эмнэлгүүдэд тавих хяналт сайжирч, иргэдэд үйлчлэх үйлчилгээ чанаржиж, малын өвчлөл багасах мөн тархвар судлаачийн орон тоо бүтэн ажилласнаар сумдын малын халдварт өвчний голомтын судалгааг нарийн тогтоож өвчлөлтэй бүс нутгийн мал вакцинд бүрэн хамрагдана.

Мал, амьтны өвчний оношилгоо, шинжилгээний чадавхыг сайжруулах чиглэлээр:

Төсвийн хөрөнгөөр 2019 онд 14400.0 мянган төгрөгийн үнэтэй лабораторийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, багаж, эм урвалж авсан байна.

Аймгийн мал эмнэлгийн газрын лабораторийн 2 шинжлэгч эмч сургалтад хамрагдаж анхан шатны шинжилгээг тогтмолжуулсан байна. Зах зээлд борлуулагдаж байгаа мах, сүүний дээжид ус, сод, гурил, цардуул хольсон эсэх, мастит илрүүлэх зэрэг шинжилгээг хийсний үндсэн дээр мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ олгож байна. Тухайн зорилтын хүрээнд орон нутагт хаана, хэзээ, хэдэн малын гаралтай бүтээгдэхүүнд чанарын шинжилгээ хийж, мал эмнэлэг, ариун цэврийн баталгаажуулалттайгаар хүн амын хүнсний бүтээгдэхүүнд нийлүүлсэн талаар тодорхой ажил хийгдээгүй байна. Хүнсний зах, түүхий эдийн цэгүүдийн ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл сайжирсан талаар хийсэн ажил байхгүй байна.

Мал эмнэлгийн дуудлага үйлчилгээний шуурхай бэлэн байдлыг хангах чиглэлээр:

Мал эмнэлгийн дуудлага, үйлчилгээний шуурхай бэлэн байдлыг хангахад зориулан МЭЭГ-аас Лада авто машин аймгийн МЭГ-т, 19-н мотоцикл сумдын мал эмнэлгийн тасагт өгсөн байна. 2019 онд 106 өвчний дуудлага, 2020 онд 102 дуудлага ирж очиж үйлчилсэн байна. Дуудлагын ихэнх нь гэрийн тэжээвэр амьтан нохой, муур эзэлдэг харин хонь 4, ямаа 2, адуу 21, үхэр 2 хамрагдсан байна. Дуудлага үйлчилгээний бэлэн байдлыг хангаснаар халдварт өвчний сэжигтэй өвчин мал, амьтны дуудлагад хаашаа, хэдэн удаа явж малын халдварт өвчин яаж буурсан талаар тодорхой тайлагнаагүй байна.

Мал, амьтны шилжилт, хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах зорилтын хүрээнд:

2020 оноос Улсын хэмжээнд Мал эмнэлгийн нэгдсэн систем нэвтэрч шилжилт хөдөлгөөнийг хянаж баталгаажуулах боломжтой болсон боловч МЭНС-ээс харахад 2020 оны эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 939 өрхийн 478645 толгой мал отор нүүдлээр гаднын аймагт шилжилт хөдөлгөөн хийсэн байна. Хамгаалалтын бүс тогтоох зорилгоор давхардсан тоогоор 17 сумын 9705 өрхийн 165911 толгой үхэр, 1382666 толгой хонь, 975379 толгой ямаа, 188 толгой гахай нийт 2524144 толгой мал, амьтан шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд хамруулсан байна. Өвчний голомттой бүс нутагт отроор яваад ирсэн мал, амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж өвчний дээж авч, тархан халдварлахаас сэргийлэх арга хэмжээ авч ажилласан тайлан мэдээ байхгүй байна.

Хүнд халдварладаг зооноз өвчний гаралт, тархалтаас урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд:

Сумдын мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүд, ААН-ийн малын эмч нартай хамтарч 19 сумын 106 багийн 5430 малчин өрхийн 12345 хуц, 8807 ухна, 1122 бух, 217 буур нийт 22491 толгой хээлтүүлэгч малаас цусны дээж авч ийлдэс ялган бруцеллёз илрүүлэх



шинжилгээ хийхэд 22383 дээж сөрөг, 108 дээж эерэг урвал үзүүлж эдгээрийг элизагийн урвалаар баталгаажуулахад 81 дээжид бруцеллёзын эсрэг биет илэрсэн байна. Хүнсний зах, түүхий эдийн цэгүүдийн малын гаралтай бүтээгдэхүүнээс дээж авч шинжилгээ хийсэн тайлан байхгүй, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл сайжирсан талаар хийсэн ажил байхгүй байна.

Малын гоц халдварт, халдварт өвчний тандалт шинжилгээ хийж, гоц халдварт, худалдааны хорио цээрт өвчнөөр эрүүл баталгаа гаргаж, зарим вакцинжуулалтын ажлын үр дүнг тооцох зорилтын хүрээнд:

Мал сүргийг вакцинжуулах ажлын үр дүнг түүвэр шинжилгээ хийж эмч нарын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэн, ажлын чанарыг дээшлүүлэх зорилгоор боом өвчний голомтын хяналт, тандалт шинжилгээний дээж цуглуулах ажлыг Хужирт, Хархорин, Есөнзүйл, Өлзийт, Зүүнбаян-Улаан зэрэг голомт бүхий сумдад хийж гүйцэтгэсэн байна. Тандалт шинжилгээг эрсдэл бүхий бүс нутагт хийж заавар зөвлөгөө өгч, шинжилгээ оношлуурын арга зүйн дагуу хийж гүйцэтгэсэн байна.

Лабораторийн эмч нар ажлын байран дээрх сургалт хийж мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн байна. Лабораторийн шинжилгээг УМЭАЦТЛ-тай хамтран хийж ирсэн байна. МЭЭГ-ын даргын 2020 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн А/118 тоот тушаалаар “Монгол улсыг үхрийн цээж, ямааны годрон өвчнөөс эрүүлжсэн болохыг баталгаажуулах” ажлын албан даалгаврын хүрээнд 2020 онд төлөвлөгөө гарган ажиллаж 15 сумаас 200 үхрийн ийлдэсний дээж, ӨВ ЭКО МИЙТ ХХК, Дээжийн Өргөө ХХК, мал нядалгааны газруудад МЭГ-аас шинжилгээ авч Мал эмнэлгийн хүрээлэнд хүргүүлсэн байна.

Гэрийн тэжээвэр амьтдаас халдварладаг халдварт, паразиттай өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр:


Вакцин хийлгэх үйлчилгээ авсан 66 нохойнд эрүүл мэндийн дэвтэр авч нээлгэсэн байна.

ХХААХҮС-ын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/178 тоот тушаалаар “Малын эмийн үлдэгдлийн хяналт”-ын үндэсний хөтөлбөр баталсан байна. Үүний дагуу аймгийн мал эмнэлгийн газрын даргын “Малын эмийн үлдэгдлийн хяналт”-ын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2020-2023 оны төлөвлөгөө боловсруулан ажилласан байна. Төлөвлөгөөний дагуу Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулж байгаа 10 малын эмийн санд эм худалдаалалтыг хяналтын хуудсаар шалгахад жин хэмжүүр баталгаажаагүй, эмийн орлого, зарлага, хүлээн авах журнал, агуулахын бүртгэл хөтөлж хэвшээгүй, хадгалах хугацаа дууссан, хог хаягдлын тусгай хогийн сав байхгүй, малын эмийн сан нь байшингийн подвалд захын хажууд байрласан, эм хадгалах агуулахгүй, ажиллагсад нь эрүүл мэндийн үзлэгт хамрагдаагүй зэрэг зөрчил дутагдлууд илэрч мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна. Нийт 19 сумын 47 МЭҮН нь 31-н малын эмийн сан ажиллуулж байна.

Аудитаар малчдаас авсан санал асуулгаар:

Аудитад хамрагдсан сумдын мал эмнэлгүүдийн харьяа малчдаас мал эмнэлэг, малын эмчийн хүрэлцээ, мэргэжлийн ур чадвар, эмчилгээний чанар, хүртээмж, сэтгэл ханамжийн талаар санал асуулга авахад Нарийнтээл сумын Бумбат суварга, Бумбат-Ур, Хужирт сумын Гонир манал зэрэг мал эмнэлгүүдийн үйл ажиллагааг сайн гэж үнэлсэн, мөн тарилгын технологийн горимыг мөрдөн ажиллаж байна.

Харин дараах мал эмнэлгүүдийн үйл ажиллагаа нь хангалтгүй гомдол, саналуудыг гаргаж байна. Үүнд: Баруунбаян-Улаан, Гучин-Ус сумууд нь нэг хувийн мал эмнэлэгтэй тул малчдадаа бүрэн хүрч ажиллаж чадахгүй, чанар байдлын хувьд хангалтгүй, олон малтай айл өрхүүдээрээ орж цөөн малтай айлуудаа орхигдуулсан байдалтай байна. Мал эмнэлгийн хүрэлцээ муутай тул цөөн малтай айлууд нь өөрсдөө тарилга, туулгаа хийж ирсэн байна.



Гучин-Ус сумын Өөш шахлага мал эмнэлгийн талаар:

“Дуудлага өгөхөд ирдэггүй, малаа авчирч үзүүл гэдэг, айл өрхөөрөө ордоггүй, тарилга туулгаа эмч нь явж хийдэггүй, сумын хэмжээнд нэг мал эмнэлэг нь хүрэлцэхгүйн улмаас олон малтай айлд үйлчилдэг, мал эмнэлгийн үйлчилгээ тааруу, вакцин хүрэлцээ муутай, мал угаахдаа крелионыг нь солихгүй олон мал угаадаг, малын оношилгоо байхгүй, дэлгүүртээ хэдэн эм тариатай сууж байдаг, мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулж улсын болгомоор байна” гэсэн саналууд гарсан. Мөн баг бүр эмчтэй, өөр өрсөлдөх мал эмнэлэгтэй бол үйлчилгээ сайжирч малын өвчлөл багасна. Зөвхөн ДХХ-ын тарилга хийдэг малчид голдуу өөрсдөө тарилгаа хийдэг. Хордлогын туулга оройтож хийснээс болж мал хавар ногоо идээд үхдэг зарим халдварт өвчнөөс сэргийлэх тарилга, вакцин хийгддэггүй” гэсэн байна.

Баруунбаян-Улаан сумын Баян бударгана мал эмнэлгийн талаар:

“Сумын малын эмчээ танихгүй, тарилга туулгаа өөрөө явж хийдэггүй, малын эмчийн хүрэлцээ муу, үйлчилгээ үзүүлдэггүй, сүүлийн жилүүдэд тарилга хийгээгүй, дуудлага өгөөд ирдэггүй, тариагаа өөрсдөө хийчихээрээ гээд үлдээгээд явдаг, малын эмчийн мэдлэг муу, тарилга туулгад бүрэн хамруулдаггүй, малын эмчийн өрөө шаардлагатай, бага болгон эмчтэй баймаар байна” гэсэн байна.

Зүүнбаян-Улаан сумын Сонжин дөрөлж мал эмнэлгийн талаар:

“Цусан халдварт өвчний голомттой байсан ч малд халдварт өвчнөөс сэргийлэх тарилга хугацаа өнгөрсөн хойно хийгддэг, мал угаалгын ванн муутайгаас малчид малаа өөрсдөө угаадаг, мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах шаардлагатай, вакцинд бүрэн хамруулдаггүй, олон малтай болон хамаатан садан, найз нөхдийнхөө малд тарилга хийчхээд, цөөн малтай, амьдрал дорой өрхийн малд эм тарилга хийж үйлчилдэггүй, сумын 4 багаа хариуцан ажилладаг тул малын эмчийн хүрэлцээ хангамж муутай, баг бүрд эмчтэй баймаар байна” гэсэн байна.

Зүүнбаян-Улаан сумын Сонжин дөрөлж мал эмнэлэг нь аймгийн МЭГ-ын мал, амьтан эрүүл мэндийн албаны дарга Б.Алтанзулын хамаарал бүхий ААН байна. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д “Албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй бөгөөд албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байна”, 11 дүгээр зүйлийн 11.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Сумдын мал эмнэлгүүд нь эм тарилга, вакцин хугацаандаа нийлүүлэгдэхгүй байгаагаас цусан халдварт, галзуу, хордлогын тарилга, дуутын тарилга хийгдээгүй малд хийвэл зохих технологит хугацаа хоцорч байна. Энэ нь Биокомбинатын үйлдвэрлэл нь ачаалал ихтэй байгаа тул вакцины нийлүүлэлт удаашралтай байдагтай мөн холбоотой байна.

Мал угаалгын ванн 2020 онд 11 суманд 16 ширхгийг 240.0 сая төгрөгийн төслийн хөрөнгөөр, 6 суманд 19 ширхгийг 300.0 сая төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн баригдсан боловч мал угаахад тохиромжгүй малын хөл гэмтэхээр хийгдсэн гэсэн шалтгаанаар зарим сумдад ашиглаагүй мал угаалгын ажил бүрэн хийгдэхгүй байна. Нийт 540.0 сая төгрөгийн хөрөнгийг ашиглалтад оруулан малчдад үйлчилгээ үзүүлж ажиллах шаардлагатай байна. Малчид одоогийн байдлаар боломжтойн малаа хашаанд хийж байгаад шүршиж угаадаг, ихэнх нь малаа сүүлийн хэдэн жил угаагаагүй гэж байна.



Зураг-1 Мал угаалгын ванны зураг /Доторх бохир зайлуулаагүй, дотор нь мал үхсэн/



Аудитаар малын эмч нараас авсан санал асуулгаар:

- ◆ Малын эм, био бэлдмэлийн захиалга, нийлүүлэлт шаардлагад хэр нийцэж байна вэ гэхэд: Малын тооноос харьцангуй бага ирдэг, сохор догол, хордлого үйлдвэрээсээ бага ирдэг, захилгын тооноос хасагдаж ирдэг, захиалга хугацаа хоцорч ирдэг.
- ◆ Аймгийн мал эмнэлгийн газраас хуваарилалтад аль нэг мал эмнэлэгт давуу байдал олгодог уу гэхэд: Нийлүүлэлт харьцангуй өөр өөр байдаг, давуу байдал ажиглагддаг.
- ◆ Үйлчилгээний зардал бодитой байна уу гэхэд: Ихэнх нь үйлчилгээний хөлс бага
- ◆ Танай мал эмнэлгээс захиалж буй малын эм, био бэлдмэлийн захиалга төлөвлөсний дагуу ирж байна уу гэхэд: Ихэвчлэн дутуу ирдэг.
- ◆ Халдварт өвчин гарсан үед ариутгалын бодисын хүрэлцээ ямар байна гэсэн асуултад: Боломжийн, хүрэлцээтэй, өөрсдөө нөөцөлдөг гэсэн хариултуудыг тус тус өгчээ.

2.2. Мал эмнэлгийн ажил үйлчилгээний зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.


ХХААХҮС-ын 2018 оны А/174 дугаар тушаалаар аймаг, сумдын мал эмнэлгийн газрын бүтэц, орон тоог баталсан байна. Аймгийн Мал эмнэлгийн газар 29 орон тоо, 19 сумын 38 орон тоо баталсан боловч 2019 онд аймгийн Мал эмнэлгийн газар 25 орон тоо, умууд 27 орон тоотой ажилласан байна. Мэргэжилтний хүрэлцээ хангамж муу нийт батлагдсан орон тоондоо ажиллаж чадаагүйгээс цалингийн сан их хэмнэгдсэн байна.

2020 онд үндсэн дансаар 764983.3 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Үүнээс томоохон зардлуудыг дурдвал:

- Цалингийн зардалд 146954.2
- Нэмэлт цалинд 41576.3
- Тээвэр шатаахуунд 19733.8
- Багаж, техник хэрэгслийн зардалд 25393.6
- Урсгал засварт 22315.6
- Түлш халаалт 16132.6
- Бусад нийтлэг үйлчилгээний зардалд 341517.6 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 482073.0 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнээс:

- Цалингийн зардалд 226399.9
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 14038.9
- Тээвэр шатаахуунд 16213.9
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 398740.2 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.



Аймгийн Мал эмнэлэг нь 2019 онд үндсэн дансаар 974735.5 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Үүнээс томоохон зардлуудыг дурдвал:

- Цалингийн зардалд 146954.2
- Нэмэлт цалинд 41576.3
- Тээвэр шатаахуунд 19733.8
- Багаж, техник хэрэгслийн зардалд 25393.6
- Урсгал засварт 22315.6
- Түлш халаалт 16132.6
- Бусад нийтлэг үйлчилгээний зардалд 341517.6 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтээр 2019 онд 41576.3 мянган төгрөгийн санхүүжилт авч дараах байдлаар зарцуулсан байна. Тухайлбал:

- Цалингийн зардалд 226399.9
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 14038.9
- Тээвэр шатаахуунд 16213.9
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 398740.2 мянган тус тус төгрөг зарцуулсан байна.


Хүснэгт-2 *Зориулалт бусаар зарцуулсан зардлын жагсаалт /мян.төг/*

№	Зардлын төрөл	Зориулалт бусаар гарсан зардал	Мөнгөн дүн
2019 он			
1	Цалингийн зардал	Туслах ажилчдад урамшуулал	2230.1
2		Ажилчдын үр дүнгийн урамшуулал	7347.0
3	Бусад нийтлэг үйлчилгээний зардал	Тавилга	5209.9
4		Зочид буудлын тооцоо	633.4
5		Хоолны зардал	1268.0
6		Малын багаж хэрэгсэл	7179.0
7		Гадаад томилолтын зардал	3365.0
8	Түлш халаалтын зардал	Мал эмнэлгийн газрын 46 ажилтанд тус бүрийн 1 тн нүүрс олгосон	3940.0
Нийт дүн			31172.4
2020 он			
1	Бусдаар гүйцэтгүүлэх зардал	Ажилчдын үр дүнгийн урамшуулал	1963.8
2		Тавилга	700.0
3		Компьютер тоног төхөөрөмж	4979.9
4		Хоолны зардал	483.7
5		Барилгын материал	2194.5
Нийт дүн			10321.9

2.3. Хувийн мал эмнэлгүүдийн ажиллах орчин нөхцөл тааруу, үйлчилгээний чанар хүртээмж хангалтгүй байна.³

Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан Гучин-Ус сумын Өөш шахлага, Баруунбаян-Улаан сумын Баян бударгана, Зүүнбаян-Улаан сумын Сонжин дөрөлж, Дөлгөөн сүрэг, Өрнөх дөлгөөн, Нарийнтээл сумын Бумбат сувраг, Бумбат-Ур, Арвайхээр

³ 30.1.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх итгэмжлэл бүхий малын эмчтэй, стандартын шаардлага хангасан байр, тоног төхөөрөмжтэй, мал эмнэлгийн үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд байна.



сумын ДС-Дөхөм, Үржин дэвших, Баян сүргийн буян, Арвайн талын буян гэсэн мал эмнэлгүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцлаа.

Зарим мал эмнэлгүүд нь үйлчилгээ явуулах боломж тааруу, ажиллах орчин нөхцөл хангалтгүй байна. Тухайлбал:

- ◆ Гучин-Ус сумын Өөш шахлага, Баруунбаян-Улаан сумын Баян бударгана мал эмнэлгүүд нь халаалт байхгүй, гэртэйгээ хамт, малчид үйлчлүүлэх боломж муутай байна.
- ◆ Зүүнбаян-Улаан сумын Сонжин дөрөлж мал эмнэлэг нь ажлын байр нь үйлчилгээ явуулах боломжгүй, малчид орж үйлчилгээ авах орчин нөхцөл бүрдээгүй, малчид үйлчилгээ авдаггүй байна.

Зураг-2 Гучин-Ус сумын Өөш шахлага эмнэлэг /халаалтгүй/



Зураг-3 Зүүнбаян-Улаан сумын Сонжин дөрөлж эмнэлэг /ажиллах орчин муу/



Зураг-4 Баруунбаян-Улаан сумын Баян бударгана эмнэлэг /гэрийнхээ 1 давхарт, хойш харсан хаалгатай/





Өөрийн үйл ажиллагаа явуулах ажлын байр байхгүй, мал эмнэлгийн үйлчилгээ явуулах боломжгүй мал эмнэлгийн нэгжүүд нь мал эмнэлгийн зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- ◆ Арвайхээр сумын Арвайн талын буян
- ◆ Зүүнбаян-Улаан сумын Дөлгөөн сүрэг, Өрнөх дөлгөөн
- ◆ Өлзийт сумын Баян ханхал, Баяндалайн баялаг мал эмнэлгийн нэгжүүд байна.

Төсвөөс жил бүр санхүүжилт авч байгаа боловч хувийн мал эмнэлгүүдийн ажиллах орчин нөхцөл тааруу байна.

Гучин-Ус, Баруунбаян-Улаан, Хайрхандулаан, Зүүнбаян-Улаан сумдын хувийн мал эмнэлгүүдийн ажлын байр ажиллах нөхцөл байдалд аймгийн мал эмнэлгийн газар болон сумдын улсын байцаагч нараас хяналт шалгалт хийж албан шаардлага хүргүүлсэн юм байхгүй байна.

2.4. Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийн үйл ажиллагаа хуулийн дагуу явагдсан боловч өөрийн орлогоо төсөвт тусгаагүй байна.

Нарийнтээл суман дахь мал эмнэлэг хорио цээр хяналтын цэгээр дамжин өнгөрч байгаа авто тээврийн хэрэгсэл, мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, дайвар бүтээгдэхүүний тээвэрлэлт, аюулгүй байдал, эрүүл мэнд, ариун цэвэр мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт тавьж зөрчил гарсан тохиолдолд зүс им тамга, МЭГ-ын кодтой тулгаж шаардлагатай нөхцөлд орон нутгийн эрх бүхий албан тушаалтантай холбогдож МЭГ-аас ариутгал халдваргүйтгэл хийж ирсэн байна.

Нарийнтээл сумын мал эмнэлэг хорио цээрийн постоор:


2019 онд 20459 авто тээврийн хэрэгсэл нэвтэрснээс 1084 авто машинд ариутгал хийгдсэн, 45163 амьд мал, 33021 тн мах, 55 ширхэг тэмээний шир, 233 ширхэг үхрийн шир, 3500 ширхэг хонины нэхий, 4988 ширхэг ямааны арьс, 1047 тн хонины ноос, 58.3 тн ноолуур нийт 72270 тн түүхий эдийн бүтээгдэхүүний шилжилт хөдөлгөөнд хяналт тавьсан

2020 онд 16840 авто тээврийн хэрэгсэл нэвтэрснээс 1096 машинд ариутгал хийсэн, 14779 мал, амьтан, 1841200 тн мах, 207512 ширхэг арьс шир, 29.5 тн ноос ноолуур, 326.3 тн адууны дэл, 6.5 тн ааруул, 1160 литр сүү, 39.7 тн цувдай, 2000 ширхэг үхрийн шир 9405 ширхэг өлөн гэдэс, 7 тн сүүл, 60 литр айраг, 100 кг аарц, 5 кг эээгий, 3 тн үхрийн борц зэрэг мал, амьтны гаралтай түүхий эдийн бүтээгдэхүүн байнгын хяналтын постоор нэвтэрсэн байна.

Аймаг, сумын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийн мал эмнэлгийн улсын байцаагч нь мал эмнэлгийн нэгдсэн системийг ашиглан мал амьтны отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг бүрэн хяналтад авч, үнэлэлт дүгнэлт өгч ажиллах үүрэг, эрхтэй байдаг. Гэвч манай аймгаас бусад аймаг, суманд отроор явж байгаад ирсэн малд үзлэг, шинжилгээ хийх тооцоо судалгаа байхгүй байна. Ямар өвчтэй мал ирж байгаа талаар хянасан тандалт судалгаа бүрэн хийгдээгүй байна.

Мал эмнэлгийн хорио цээрийн төв нь аймгийн ИТХ-ын 2015 оны “Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний жишиг үнэлгээний жагсаалт батлах тухай” 10/02 дугаар тогтоолоор баталсан жишиг үнэлгээгээр мал ачсан нэг машинаас 3500, 5000 төгрөгөөр орлогоо тооцсон байна.

Өөрийн орлогоо арилжааны банканд нярвын нэр дээр данс нээж 2019 онд 7700.2 мянган төгрөг, 2020 онд 15682.6 мянган төгрөг оруулж, 23382.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан боловч аймгийн Мал эмнэлгийн газрын 2019, 2020 онуудын санхүүгийн тайланд тусгаагүй байна.



БҮЛЭГ-3. МАЛ ЭРҮҮЛЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТЫН ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

3.1. Аймгийн Мал эмнэлгийн газраас сумын мал эмнэлгийн тасгуудад жил бүр хяналт, шалгалт хийгдсэн боловч хяналт, шалгалтын дагуу сумдад өгөгдсөн зөвлөмжийн биелэлт тооцсон баримт байхгүй байна.

Аймгийн Мал эмнэлгийн газраас 2019, 2020 онуудад 2 удаа 19 суманд хяналт, шалгалт хийсэн байна. Тус хяналт, шалгалтаар сумдын мал эмнэлгийн тасгууд, мал эмнэлгийн нэгжүүд, малчдыг хамруулж өрхийн дэвтрийн бичилттэй танилцах, санал асуулга авах байдлаар ажилласан байна.

Сумдад хяналт, шалгалт хийгдсэн ажлын чиглэл:

2019 онд Өвөрхангай аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дүгээр хяналт шалгалтын удирдамжийн дагуу 19 сумын Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд, малчдыг хамруулан 2019 оны 05 дугаар сарын 13-24-ний өдрүүдэд хяналт шалгалт хийсэн. Шалгалт хийгдсэн чиглэл:

1. MNS 5368:2018 стандартын хэрэгжилт шалгах.
2. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн шуурхай бэлэн байдлыг шалгах. Мал эмнэлгийн хяналтын цэгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, нэгдсэн удирдлага арга зүйгээр хангах.
3. Малын шилжилт хөдөлгөөний зохицуулах, тээвэр тууврын замд хорио цээрийн хяналтад авах журамд заасан бүрэн эрхийн хүрээнд туувар, тууврын мал түр амрах, хоноглох цэгийг тогтоох саналыг боловсруулж сумын Засаг даргын шийдвэр гаргуулсан эсэх. Малын угаалга, халдваргүйтгэл, төлөвлөгөөт болон яаралтай дархлаажуулалтад явцын хяналт шалгалт хийх /нийт гэрээт өрхийн 30-с доошгүй хувьд/
4. Малын эмийн замбараагүй хэрэглээнд хяналт тавих
5. Мал эмнэлэг ариун цэврийн сарын ажлын төлөвлөгөө, захирамжийн хэрэгжилтийг шалгах.
6. Мал амьтан мах, сүү цагаан идээний мал эмнэлгийн ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээтэй эсэхийг шалгах /албан байгууллагын гал тогоо бүхийн газар/
7. Төв суурин газарт сүү цагаан идээ, мах худалдаалж буй цэгт мал эмнэлгийн ариун цэврийн лабораторийг тухайн аж ахуй нэгж тогтмол ажиллуулж буй эсэх.
8. Санал асуулга авах.
9. Сургалт.

2020 онд Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01/85, 03 тоот удирдамжийн дагуу сумдын Мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгжид “Малын эрүүл мэндийн нэгдсэн систем” түүний ач холбогдлын талаар орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүдэд мэдээлэл хүргэх, сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сумын удирдлага, мал эмнэлгийн тасагтай “Хамтран ажиллах гэрээ” байгуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал дүгнэлт гаргах зорилгоор Мал эмнэлгийн газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 05 дугаар удирдамжийн дагуу сумдад ажилласан байна.

Хяналт шалгалтын дүгнэлтээр сумдад дараах зааварчилгаа өгсөн байна.

2019 онд

- ◆ Сумдын удирдлагад тасгийн мэргэжилтнүүдээс шаардлагатай мэдээллийг шаардан авч, салбарын үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллахыг зөвлөсөн.



- ◆ Нэгдсэн удирдамжийн хугацаатай мэдээ тайланг ирүүлэх, МЭҮН-д мэдээ тайлангийн маягтыг журнал болгон хавтаслаж өгөх, мэдээ тайлангийн үндэслэлийг хянаж шалгаж явах.

2020 онд:

- ◆ Тогтоол шийдвэр хувийн хэрэг хөтлөлт нээсэн боловч төлөвлөгөө биелэлт хангалтгүй, биелэлтэд үр дүн дүгнэлт хийдэг байх.
- ◆ Сарын ажлын чиглэлийн дагуу биелэлт гаргасан боловч сумын удирдлагуудад танилцуулаагүй, төлөвлөгөө боловсруулж ажилладаг байх.
- ◆ Ажлын цаг ашиглалт сайжруулах, хугацаатай мэдээ тайлан судалгааг хожимдуулахгүй байх.
- ◆ Мал эмнэлгийн халдварт паразит, халдваргүй өвчний мэдээг гаргахдаа үндэслэлийг анхаарах, өвчний тохиолдлыг бүртгэлжүүлэх, Эмнэл зүйн шинж тэмдгээр оношилсон халдварт өвчнийг лабораторийн шинжилгээгээр баталгаажуулах.
- ◆ Тасаг дотроо ажил үүргийн хуваарийг тодорхой болгох.
- ◆ Малчид иргэдийг мэдээллээр хангах материалын бүрдүүлэлт дутмаг.
- ◆ Хугацаатай бичгийг картлуулах.
- ◆ Мал эмнэлгийн нэгдсэн системд төлөвлөлт, гүйцэтгэл оруулалт хангалтгүй.
- ◆ Өрхийн эрүүл мэндийн дэвтрийн жагсаалт, хөтөлж, тарилгын жагсаалттай тулган хяналт тавьдаг байх.
- ◆ МЭҮН-ийн үйл ажиллагааг сайжруулахад анхаарч, тасаг, нэгжийн хамтын ажиллагааг бэхжүүлэх.
- ◆ Өмнөх онуудын бичиг баримтыг архивлах.
- ◆ Эмийн үлдэгдлийн хяналт хөтөлбөрт сард хэрэглэсэн эмийн чанар үр дүнгээр судалгаа гарган баяжуулах.

Дээрх чиглэлийн дагуу хяналт шалгалт хийгдэн, зөвлөмж өгч ажилласан боловч өгөгдсөн зөвлөмжүүдийн биелэлтийг гаргаагүй, албажуулсан баримт, материал байхгүй байна. Цаашид сумдын тасгууд, мал эмнэлгийн нэгжүүдийн үйл ажиллагааг тогтворжуулж чанаржуулах, хяналт, шалгалтын үр дүнг сайжруулахын тулд зөвлөмжийн биелэлтийг тооцож ажиллах шаардлагатай байна.

3.2. Сумын мал эмнэлгийн улсын байцаагч нарын хувийн мал эмнэлгийн нэгжид тавих хяналт хангалтгүй байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/457 дугаар тушаалаар батлагдсан “Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журам”-ын 2 дугаар зүйлд заасны дагуу сум, дүүрэг дэх мал эмнэлгийн тасгийн мал эмнэлгийн улсын байцаагч мал эмнэлгийн үйлчилгээний үйл ажиллагаанд дараах чиглэлээр хяналт тавихаар заасан байна. Үүнд:

- Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн ажлын байрны стандартын хэрэгжилтийг хангуулах.
- Мал, амьтны халдварт, шимэгчлэх, халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, эмчлэх арга хэмжээний технологи, үйл ажиллагаанд байнгын хяналт хэрэгжүүлэх.
- Мал, амьтны шилжилт хөдөлгөөн, мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, аюулгүй байдлын баталгаажуулалтын хяналтыг тогтмол хэрэгжүүлэх.



- Мал эмнэлгийн улсын байцаагч нь мал, амьтны эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эм бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн хэрэглээний зарцуулалтад дараах арга хэмжээг хэрэгжүүлэх.

Гэвч энэ хүрээнд мал эмнэлгийн улсын байцаагчийн хяналт хангалтгүй байна.

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн ажлын байрны стандартын хэрэгжилтийг хангуулах буюу “Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагааны MNS5368:2018 стандарт”-ын үзлэгийг жилд нэг удаа явуулж үнэлгээ өгөх тухай “Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1⁴, 2.1.2⁵, 2.1.3⁶ дэх заалтуудад тус тус заасан байдаг. Мөн Мал эмнэлгийн нэгдсэн системд мал эмнэлгийн улсын байцаагч харьяа мал эмнэлгийн нэгж тус бүрээр программд байршсан асуумжуудыг бөглөн, нотолгоо зураг хавсаргахаар тус үнэлгээ нь 2019 оноос байршсан.

Мал эмнэлгийн нэгдсэн системд байршсан 2019, 2020 оны үзлэгтэй танилцахад 2019 оны хувьд 19 сумын 47 нэгжийн асуумж бүрэн хангалттай бөглөгдөөгүй бүгд нотлох баримт хавсаргаагүй байна. 2020 оны хувьд тодорхой хэмжээгээр системд үзлэгийн мэдээлэл оруулсан боловч 19 сумын хэмжээнд мэдээлэл бүрэн байршуулаагүй байсан. Энэ нь сумын мал эмнэлгийн улсын байцаагчдаас хяналт бүрэн тавьдаггүйтэй холбоотой бөгөөд программ хөтлөлтийн хувьд зургийг бүрэн хавсаргадаггүй, тайлбар бичдэггүй, үзлэгийн дүгнэлтээр мал эмнэлгийн нэгжид алдаа зөрчлийг засуулахаар зөвлөмж, албан шаардлага өгсөн эсэхээ бүрэн мэдээлээгүй гэх алдаа дутагдлууд нийтлэг байна.

Өвөрхангай аймгийн Мал эмнэлгийн газар нь 2019 оноос эхлэн Мал эмнэлгийн нэгдсэн системийг ашиглаж байгаа бөгөөд тус систем нь хувийн мал эмнэлгийн нэгжүүд урьдчилан сэргийлэх арга хэмжээ болох вакцинжуулалтууд, угаалга, туулгалт, боловсруулалт, ариутгал, халдваргүйжүүлэлтийн мэдээллүүдийг тухай бүрд нь оруулж, үүнд мал эмнэлгийн улсын байцаагч хяналт тавьж ажиллах үүрэгтэй байна.

Аймаг, сумын мал эмнэлгийн улсын байцаагчид мал эмнэлгийн нэгдсэн системээр хяналт тавьж байгаа ба тарилга хийсэн жагсаалт, актыг сумын мал эмнэлгийн улсын байцаагч баталгаажуулалт хийж, улсын байцаагчийн дүгнэлт гаргаж хяналтыг хэрэгжүүлж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А/174 дүгээр тушаалаар 19 суманд улсын байцаагчийн орон тоо батлагдсан боловч 3 сум орон тооны улсын байцаагч байхгүйгээс сумдын мал эмнэлгүүдэд тавих хяналт хангалтгүй байх үндэслэл болж байна.

Баруунбаян-Улаан, Зүүнбаян-Улаан, Гучин-Ус сумдын МЭҮТ-ийн дарга, улсын байцаагч нарын ажлын хариуцлага сул, хувийн мал эмнэлгийн үйл ажиллагаанд хяналт тавиагүйгээс төсвөөс олгож буй тарилгыг бүрэн гүйцэд малд хийдэг эсэх, мэдээ тайлангийн үнэн зөв нь эргэлзээтэй байна.

3.3. Журмын дагуу мэдээллийг бүрэн хөтөлсөн боловч мэдээ, тайлангийн тоон үзүүлэлт зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.⁷

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/09 дугаар тушаалаар батлагдсан "Мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, тайлагнах

⁴ 2.1.1.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор ажлын байр, шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн хангалт, бэлэн байдалд батлагдсан шалгуур үзүүлэлтээр жилд нэг удаа үнэлгээ өгнө.

⁵ 2.1.2.Шалгуур үзүүлэлтийн үнэлгээний дагуу ажлын байр, багаж, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах хугацаатай үүрэг өгч, биелэлтийг хангуулна.

⁶ 2.1.3.Ажлын байр, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж чадахгүй, хугацаатай үүрэг даалгаврыг 2 ба түүнээс дээш удаа биелүүлээгүй мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн гэрээг цуцлуулах саналыг сум, дүүргийн Засаг дарга, аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газарт гаргаж шийдвэрлүүлнэ.

⁷ 22.1.Мал эмнэлгийн тасаг энэ хуулийн 8.5-д заасан журмын дагуу цуглуулсан мэдээллийг нэгтгэн тухайн нутаг дэвсгэрт бүртгэгдэж байгаа халдваргүй өвчний анхдагч мэдээллийн сан бүрдүүлнэ.



журам"-ын дагуу дараах тайлангуудыг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан хуваарийн дагуу сумын тасгийн улсын байцаагчид, аймгийн Мал эмнэлгийн газар тус бүрд нь улирал, хагас жил, бүтэн жил тайлагнадаг байна.

Батлагдсан журмын дагуу 14 нэр төрлийн мал эмнэлгийн үйлчилгээ, тарилга туулга, халдваргүйжилд, халдварт өвчний мэдээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эм бэлдмэлийн зарцуулалтын үлдэгдлийн тайлан мэдээг улирал, хагас, бүтэн жилээр гаргадаг.

Аймгийн Мал эмнэлгийн газрын Мал эмнэлгийн ерөнхий газарт нэгтгүүлсэн 2019, 2020 оны жилийн эцсийн мэдээ тайланг түүвэрчилсэн байдлаар мал эмнэлгийн нэгдсэн системийн тоон мэдээлэл, байгууллагын 2019, 2020 оны үйл ажиллагааны тайлан зэргээс тулган үзэхэд тоон мэдээллүүд зөрүүтэй тусгагдсан байна. Жишээ нь дараах зөрүүтэй тоон мэдээллүүд байна. Үүнд:

Хүснэгт-3 Шимэгчлэх өвчнөөс сэргийлэх арга хэмжээний 2020 оны жилийн эцсийн мэдээний тулгалт

№	Арга, хэмжээний нэр	Жилийн эцсийн мэдээ		Байгууллагын гүйцэтгэлийн тайлан		Зөрүү	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Туулгалт	2503240	2018527	2741881	2730641	238641	712114
2	Угаалга	5040212	2565738	5,243,866	2,670,491	203,654	104,753

Мал амьтны халдваргүй өвчний тоон мэдээллээр үхсэн малын тоо 1744 байхад, гүйцэтгэлийн тайлангаар 2095 байх гэх мэт тоон мэдээллийн зөрүүтэй байдлууд их байна.

"Мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, тайлагнах журам"-ын долоо дугаар хавсралт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн мэдээлэлд эмчийн тоог зөрүүтэй мэдээлсэн байна.

Хүснэгт-4 Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн 2020 оны жилийн эцсийн мэдээний тулгалт

№	Сум	Аж ахуй нэгжийн нэр	Аймгийн мал эмнэлгийн газрын 2020 оны жилийн эцсийн мэдээ		Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн стандартын үзлэг-2020 /мал эмнэлгийн нэгдсэн систем/-д оруулсан эмчийн тоо	Зөрүү
			Их эмч	Бага эмч		
1	Бүрд	Цогдарьт БГБХН	3		2	1
2	Баруунбаян-Улаан	Баянбударган БГБХН	1	1	1	1
3	Баянгол	Өв-Баяндагналтай ХХК	1		0	1
4	Гучин-Ус	Өөш шахлаг ХХК	1	1	1	1
5	Өлзийт	Зос хангай ХХК	3	1	1	3
6	Өлзийт	Баянханхал	2		1	1
7	Зүүнбаян-Улаан	Сонжин дөрөлж	1	1	1	1
8	Богд	Үзмэн-иш	1	1	1	1
9	Нарийнтээл	Бумбат суварга	2		1	1
10	Сант	Эрдэнэ хайрханы өгөөж	1	1	1	1
11	Тарагт	Тарагт жирэм	3		2	1
12	Уянга	Улаан цохио	1	1	1	1
13	Хайрхандулаан	Их чандмань өндөр ХХК	1	1	0	2
14	Хайрхандулаан	Хүнхэр хүүш	1	2	0	3
15	Хужирт	Гонир манал	2		1	1
16	Арвайхээр	"Баян сүргийн буян" ХХК	2	1	1	2



3.4. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээний явц чанарт аймгийн МХГ-аас хяналт тавьж ажилласан байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нийт 25 мал эмнэлгийн нэгжийн үйл ажиллагаанд “Мал амьтны эрүүл мэндийн тухай”, “Малын генетик нөөцийн тухай”, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай”, “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Зөрчлийн тухай” хуулиудын хэрэгжилтийг хангуулах, “Мал эмнэлгийн нэгжийн бүтэц, үйл ажиллагаа” Ерөнхий шаардлага MNS5368-2018 стандартын хэрэгжилтээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, аливаа эрсдэл гаргахаас урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангуулах зорилготой зөвлөн туслах үйлчилгээг явуулсан байна.

Тус төлөвлөгөөт хяналт шалгалтууд нь ерөнхий мэргэжлийн, тусламж үйлчилгээний нэгж эрхлэхэд тавигдах ерөнхий шаардлага; барилга байгууламж, тоног төхөөрөмж; хүний нөөц; мал эмнэлгийн үйл ажиллагаа; ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа; тусгай шаардлага; дотоод хяналт гэсэн 7 үндсэн бүлэг нарийвчилсан 57 үзүүлэлтээр хийгдсэн байна.

Хууль, журмыг сахин мөрдүүлэх зөвлөмж, албан шаардлагуудыг тус хяналт, шалгалтад хамрагдсан 25 мал эмнэлгийн нэгжүүдэд өгч, биелэлтийг хангаж ажилласан байна.

Хүснэгт-5

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас өгсөн үнэлгээ

№	Сум	Эмнэлэг	Шаардлага хангаагүй оноо
2019 он			
1	Хайрхандулаан	Амгалан залаа	418-с 119
2		Хүнхэрхүүш	418-с 139
3	Арвайхээр	Баян сүргийн буян	427-с 63
4		ДС-Дөхөм	427-с 137
5	Нарийнтээл	Арвайн талын буян	427-с 152
6		Бумбат суварга	418-с 104
7		Бумбат-Ур	421-с 152
8	Уянга	Улаан цохио	418-с 89
9	Зүүнбаян-Улаан	Дөлгөөн сүрэг	418-с 133
10	Хужирт	Гуа харз	427-с 192
2020 он			
1	Бүрд	Жаргалантын зон	1120-с 650
2	Богд	Үзмэн-Иш	1120-с 250
3	Баянгол	Эх-Онги	1120-с 240
4		Өв-Баяндагналтай	1120-с 500
5	Сант	Эрдэнэхайрхан өгөөж	1100-с 210
6	Есөнзүйл	Чиндөрвөн мэнд	1120-с 480
7	Арвайхээр	ДС-Дөхөм	1120-с 310
8	Хархорин	Жалбаа таван эрдэнэ	1080-с 410
9		Дэлийн бүрд	1100-с 340
10	Өлзийт	Баянханхал	1080-с 340
11	Гучин-Ус	Өөш шахлаг	1120-с 350
12	Тарагт	Дүүрэн арвин буян	1080-с 240
13	Хужирт	Гуа харз	1120-с 380
14		Гонирманал	1120-с 350
15	Уянга	Цантгялаан	1120-с 440

Дээрх хүснэгтээс харахад ерөнхий шаардлагын хүрээнд дээрх хяналт, шалгалтад хамрагдсан эмнэлгүүд 2019 онд 56.0-82.0 хувьтай, 2020 онд 31.5-78.0 хувьтай хангалтгүй үнэлэгдсэн байна.



ДҮГНЭЛТ

БҮЛЭГ 1. МАЛ ЭМНЭЛГИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨРӨНГИЙГ ҮНДЭСЛЭЛГҮЙ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

1.1. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эм бэлдмэлийн захиалгын төлөвлөлт үндэслэл муутай байна.

1.2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд орон нутгийн төсвөөс олгож буй хөрөнгийг мал эмнэлгийн нэгжүүдэд харилцан адилгүй хувиар олгосон байна.

1.3. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээний жишиг үнэлгээг тогтоосон тооцоолол байхгүй байна.

БҮЛЭГ-2. МАЛ ЭМНЭЛГИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ БҮРЭН ХИЙГДЭЭГҮЙ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

2.1. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хугацаандаа нийлүүлэгдээгүй, зарим мал эмнэлгийн нэгжүүд хангалтгүй ажиллаж байна.

2.2. Мал эмнэлгийн ажил үйлчилгээний зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

2.3. Хувийн мал эмнэлгүүдийн ажиллах орчин нөхцөл тааруу, үйлчилгээний чанар хүртээмж хангалтгүй байна.

2.4. Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийн үйл ажиллагаа хуулийн дагуу явагдсан боловч өөрийн орлогоо төсөвт тусгаагүй байна.

БҮЛЭГ-3. МАЛ ЭРҮҮЛЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТЫН ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

3.1. Аймгийн Мал эмнэлгийн газраас сумын мал эмнэлгийн тасгуудад жил бүр хяналт, шалгалт хийгдсэн боловч хяналт, шалгалтын дагуу сумдад өгөгдсөн зөвлөмжийн биелэлт байхгүй байна.

3.2. Сумын мал эмнэлгийн улсын байцаагч нарын хувийн мал эмнэлгийн нэгжид тавих хяналт хангалтгүй байна.

3.3. Журмын дагуу мэдээллийг бүрэн хөтөлсөн боловч мэдээ, тайлангийн тоон үзүүлэлт зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

3.4. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээний явц чанарт аймгийн МХГ-аас хяналт тавьж ажилласан байна.

ЗӨВЛӨМЖ

Мал эмнэлгийн газрын дарга А.Нямдаваа, мал, амьтны эрүүл мэндийн албаны дарга Б.Алтанзул нарт:

1. Аймаг, сумдын мал эмнэлгийн байгууллагууд нутаг дэвсгэрийнхээ малын өвчний судалгаа, өвчний гаралт, тархалтын байдлыг нарийвчлан тогтоож, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулж байх.
2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардлыг сумдын захиалгын дагуу үндэслэлтэй төлөвлөж, мал эмнэлгийн нэгжүүдэд бодитой хуваарилж байх.
3. Аймгийн Мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах хөтөлбөрийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах.
4. Улсын төсөв болон төслөөр баригдсан 540.0 сая төгрөгийн угаалгын ванныг бүрэн ашиглалтад оруулан мал угаалгын ажлыг сайжруулах.
5. Сумдын боловсон хүчний хүрэлцээ хангамж, чадавхыг сайжруулж, орон тоог бүрэн ажиллуулах.
6. Мал эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулах талаар улсын байцаагч нарын хяналтыг сайжруулж, шаардлага хангахгүй ААН-д хариуцлага тооцож ажиллах.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол улс, Өвөрхангай аймаг
Арвайхээр сум, Нутгийн удирдлагын ордон
Утас: +976 70323253, 70323833, 70323108
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn, цахим хуудас: www.audit.mn